НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 06 дугаар сарын 29 Дугаар 42 Улаанбаатар хот

Амьжиргааг дэмжих зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн хороод тус бүрд Амьжиргааг дэмжих зөвлөл байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг жигд, хүртээмжтэй явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга (И.Баттөгс)-д даалгасугай.

ДАРГА А.БАЯР